



ИНТЕРНЭТ БАНК

Түгээмэл асуулт хариулт

1. ЕРӨНХИЙ

1.1 Дэд ерөнхий

- 1.1.1 Интернет банк яагаад шинэчлэгдсэн бэ?
- 1.1.2 Шинэ интернет банк, хуучин интернет банк нь юугаараа ялгаатай вэ?
- 1.1.3 Хойшид байнга хуучин интернет банкаа ашиглаж болох уу? Заавал шинэчлэгдсэн интернет банк ашиглах уу?
- 1.1.4 Үйлчилгээний боломжууд нэмэгдэж байгаа юу, давуу тал юу вэ?
- 1.1.5 Гарын авлага, заавар зөвлөмжийг хаанаас авах вэ?
- 1.1.6 Хэрхэн Интернет банкны холболтоос гарах вэ?
- 1.1.7 Гүйлгээ хийх эрхтэй байгууллагын хувьд Байгууллага зөвхөн интернет банкаар гүйлгээ хийх эрхтэй, бусад нэмэлт үйлчилгээ байхгүй юу?

1.2 Бүртгэл

- 1.2.1 16 настай Интернет банкны үйлчилгээнд бүртгүүлж болох уу?
- 1.2.2 Хэрхэн Интернет банкны үйлчилгээнд бүртгүүлэх вэ?
- 1.2.3 Онлайн бүртгэл гэж юу вэ?
- 1.2.4 Гадаад улсын иргэн онлайнаар Интернет банкны үйлчилгээнд бүртгүүлж болох уу? / Гадаадад байгаа хүн дансан дээрээ интернет банкны эрх яаж нээлгэх вэ?
- 1.2.5 Гадаадад байгаа харилцагч яагаад интернет банкинд онлайнаар бүртгүүлж болохгүй вэ?

1.3 Нөхцөл

- 1.3.1 Интернет банк үйлчилгээ нь хураамжтай юу?
- 1.3.2 Интернет банкны хугацааг хэрхэн сунгуулах вэ?

1.4 Нэвтрэх хуудас

- 1.4.1 Интернет банкны хэлийг яаж солих вэ?
- 1.4.2 Хэрхэн Интернет банкинд нэвтрэх вэ?

2. ИНТЕРНЭТ БАНКНЫ ЛИМИТ, ЭРХ НЭМЭГДҮҮЛЭХ

2.1 Лимит

- 2.1.1 Интернет банкны өдрийн гүйлгээний лимит хэд байдаг вэ? Лимитээ шууд нэмэх боломжтой юу?
- 2.1.2 Интернет банкаар өөрийн данс хооронд хийсэн гүйлгээг өдрийн гүйлгээний лимитэд тооцдоггүй байх боломж бий юу?

2.2 Эрх

- 2.2.1 Интернэт банкны эрх хэдэн жил байдаг вэ?
- 2.2.2 Хязгаарлагдмал эрхээ яаж нэмэгдүүлэх вэ?
- 2.2.3 Байгууллага Интернэт банкны эрх авахад ямар бичиг баримт шаардлагатай байдаг вэ?
- 2.2.4 Байгууллагын Интернэт банкны эрх дээд тал нь хэдэн хэрэглэгч бүртгэж болох вэ?

3. ГҮЙЛГЭЭ

3.1 Өөрийн данс хооронд

- 3.1.1 Онлайнаар данс нээлгэсэн харилцагч тухайн данснаасаа гүйлгээ хийж болох уу? Интернэт банкны эрх дагалдах уу?

3.2 Банк хооронд

- 3.2.1 Интернэт банкаар банк хооронд гүйлгээ хийхэд шимтгэл нь хэд байдаг вэ?
- 3.2.2 Интернэт банкаар банк хоорондын гүйлгээ хийвэл хэзээ орох вэ?
- 3.2.3 Интернэт банкаар байгууллагынхаа данс хооронд их дүнтэй гүйлгээ ажлын цагийн дараа хийвэл шууд орох уу?

3.3 Гадаад шилжүүлэг

- 3.3.1 Интернэт банкаар гадаад гуйвуулгын гүйлгээ хийж болох уу?

3.4 Гүйлгээний лавлагаа

- 3.4.1 Интернэт банкаар гүйлгээ хийсэн баримтаа хэрхэн авах вэ? Тамгатай баримт гарах уу?

3.5 Захиалгат шилжүүлэг

- 3.5.1 Зээлийн данстай захиалгат шилжүүлгийг холбож болох уу?

3.6 Э-токен

- 3.6.1 Э-токен гэж юу вэ?
- 3.6.2 Э-токен төхөөрөмжийн үнэ хэд вэ? Хувь хүн авах боломжтой юу?
- 3.6.3 Байгууллага э-токен төхөөрөмжийг 50 сая төгрөгний гүйлгээ хийх үед ашиглах уу?

3.7 Бусад

- 3.7.1 Түргэн холбоос цэсэнд хадгалсан гүйлгээний загвар хадгалагдах уу?
- 3.7.2 Интернэтгүй тохиолдолд гүйлгээ хийх ямар боломж байгаа вэ?

4. ХАРИЛЦАХ

- 4.1 Интернет банк дээр хамтран эзэмшдэг дансаа хэрхэн нэмэх вэ?
- 4.2 Интернет банкаар хуулгаа хэрхэн шалгах вэ? Хэдий хугацааны хуулга шалгах боломжтой вэ?
- 4.3 Гүйлгээний хуулга татахад ямар форматаар татагдах вэ?
- 4.4 Файлаар татагдсан дансны хуулга нь тамгагүй тул хүчин төгөлдөр бичиг баримтанд тооцогдох уу?

5. ХАДГАЛАМЖ

5.1 Хадгаламж хаах

- 5.1.1 Интернет банкаар хадгаламжийнхаа хугацааг цуцалж болох уу?

5.2 Хадгаламж сунгах

- 5.2.1 Интернет банкаар бүх төрлийн хадгаламжийн хугацааг сунгаж болох уу?

6. ЗЭЭЛ

6.1 Зээлийн төлбөр

- 6.1.1 Интернет банкаараа зээлээ төлж болох уу? Урьдчилж зээлээ хааж болох уу?
- 6.1.2 Зээлийн төлбөр төлөх цэсээр ямар, ямар зээл төлж болох вэ?

6.2 Зээлийн график

- 6.2.1 Интернет банкаар зээлийн мэдээллийг харж болох уу? Хугацаа, зээлийн төлөлт, хүү, нийт зээлийн хэмжээ гэх мэт.

7. КАРТ

7.1 Карт захиалга

- 7.1.1 Интернет банкаар кредит карт захиалах боломжтой юу?

7.2 Пин код

- 7.2.1 Картын пин кодыг интернет банкаар захиалж авах үйлчилгээ байгаа юу?

7.3 И-код

- 7.3.1 И-код гэж юу вэ? Пин кодоос юугаараа ялгаатай вэ? Картын И-код хэрхэн авах вэ?
- 7.3.2 И-кодоо мартсан тохиолдолд Интернет банкаар авах боломжтой юу?

- 7.3.3 Гадаадад байгаа тохиолдолд И-код хэрхэн авах вэ? /и-банктай, и-банкгүй харилцагчийн хувьд/
- 7.3.4 Э-токентой бол интернэт худалдан авалт хийхэд И-код авах шаардлагатай юу?

8. ТӨЛБӨР

8.1 Байрны төлбөрийг Интернэт банкнаас төлж болох уу?

9. МИНИЙ САНХҮҮ

9.1 Ерөнхий

- 9.1.1 “Миний санхүү” гэж юу вэ?

9.2 Төсөв

- 9.2.1 Төсөв үүсгэх ямар давуу талууд байгаа вэ?
- 9.2.2 Миний санхүү – Төсвийн жагсаалт - “Хамтарсан” гэсэн төсөв нь ямар учиртай вэ?

9.3 Гүйлгээ

- 9.3.1 Миний гүйлгээ яагаад буруу ангилагдсан бэ? Ийм тохиолдолд яах вэ?
- 9.3.2 Бусад банкны карт, дансаар хийсэн гүйлгээгээ авто-холбуулах боломжтой юу?
- 9.3.3 Миний санхүү – “Гүйлгээний дүрэм” цэс нь ямар учиртай вэ?
- 9.3.4 Миний санхүү – Төсвийн жагсаалт – “Онцгой” дотор хамрагч нэмснээр цаад хүндээ ямар мэдээлэл очих вэ? Интернэт банкгүй харилцагчийг хамтрагчаар нэмж болох уу? Хамтрагч нь тухайн төсөвт хэрхэн мөнгө хийх, худалдан авалт хийх вэ?

9.4 Ангилал

- 9.4.1 Миний гүйлгээг хэрхэн ангилж байгаа вэ?
- 9.4.2 Миний санхүү – Ангиллын жагсаалт дотор хугацаа нь зөвхөн энэ сарын мэдээлэл харагдах уу? Жишээ нь: Цалин гэсэн ангилалд сүүлийн удаагийн цалингийн мэдээлэл харагдаж байна.
- 9.4.3 Шилжүүлэг гэж ямар гүйлгээний төрөл вэ?

10. ОНЛАЙН ТОДОРХОЙЛОЛТ

10.1 Интернэт банкаараа дансны онлайн тодорхойлолтыг хэрхэн авах вэ? Тодорхойлолтын кодыг хаанаас авах вэ?

11. ХУВИЙН ТОХИРГОО

11.1 Хувийн мэдээлэл

- 11.1.1 Утасны дугаар болон и-мэйл хаяг зэрэг мэдээллээ яаж өөрчлөх вэ?
- 11.1.2 Онлайн бүртгэлээр банкинд бүртгэлтэй имэйл хаяг, утасны дугаараа өөрчилж болох уу?
- 11.1.3 Интернет банкны нууцлалаа алдсан бол яах вэ?

11.2 Нэвтрэх нэр

- 11.2.1 Интернет банкны үйлчилгээнд бүртгүүлэхэд банкнаас өгсөн нэвтрэх нэр болон нэвтрэх нууц үгийг сольж болох уу?
- 11.2.2 Интернет банкаар хэрэглэгчийн нэвтрэх нэрийг сольж болох уу?
- 11.2.3 Харилцагчийн дугаар гэж юу вэ? Ямар тохиолдолд хэрэглэх вэ?
- 11.2.4 Интернет банкинд нэвтрэх банкнаас олгосон хэрэглэгчийн дугаараа мартсан тохиолдолд хэрхэн сэргээх вэ?

11.3 Нууц үг

- 11.3.1 Онлайнар бүртгүүлсэн харилцагчийн хувьд, банкнаас ирүүлсэн хоёр янзын нууц үгний алинаар нь нэвтрэх вэ?
- 11.3.2 Нууц үгээ хэрхэн солих вэ?
- 11.3.3 Интернет банкинд нэвтрэх нууц үгээ мартсан бол яаж дахиж авах вэ?
- 11.3.4 Батлах нууц үг ашиглахгүйгээр гүйлгээ хийх боломжтой юу?
- 11.3.5 Интернет банкинд нэвтрэх нууц үгээ блоклочихлоо, блокоо яаж гаргах вэ?
- 11.3.6 Байгууллагын Интернет банкны нууц үгээ блоколсон ба э-токен төхөөрөмж ажиллахгүй байна?

12. ТУСЛАМЖ

12.1 Интернет банкны ханшийн самбар тогтмол ямар хугацаанд хэдэн цагт шинэчлэгдэх вэ?

12.2 Салбар, АТМ –ийн байршлыг жагсаалтаар харах боломжтой юу?

1. ЕРӨНХИЙ

1.1 Дэд ерөнхий

1.1.1 Интернет банк яагаад шинэчлэгдсэн бэ?

Харилцагч салбарт ирэлгүй Интернет банкаар дамжуулан авч болох бүтээгдэхүүн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, мөн хиймэл оюун ухаанд суурилан илүү хялбар, ухаалаг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилготойгоор шинэчлэгдсэн.

1.1.2 Шинэ интернет банк, хуучин интернет банк нь юугаараа ялгаатай вэ?

Шинэчлэгдсэн Интернет банк нь:

- Хиймэл оюун ухаан, харилцагчийн зан төлөв болон хэрэглээнд суурилсан
- Шинэлэг өнгө, дизайн болон бүтэцтэй
- Илүү олон нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг агуулсан (Жишээ нь, та салбарт ирэлгүй, Интернет банкны “Зээл” үндсэн цэсний “Зээлийн төлбөр төлөх” дэд цэсээр дамжуулан зээлийн төлбөрийг төлөх боломжтой болсон).

1.1.3 Хойшид байнга хуучин интернет банкаа ашиглаж болох уу? Заавал шинэчлэгдсэн интернет банк ашиглах уу?

Харилцагч шинэчлэгдсэн болон хуучин Интернет банкуудыг тодорхой хугацаанд зэрэг ашиглаж болох бөгөөд цаашид зөвхөн шинэчлэгдсэн Интернет банкыг ашиглуулах болно.

1.1.4 Үйлчилгээний боломжууд нэмэгдэж байгаа юу, давуу тал юу вэ?

Шинэ боломжууд:

- Харилцах данс нээх болон хаах
- Хадгаламж сунгах болон хаах
- Дебит карт нөхөн авах болон сунгах
- Карт блок хийх / гаргах
- Дижитал зээл авах
- Зээлийн график харах

- Миний Санхүү цэсээр дамжуулан Төсөв болон Ангилал нэмэх, Гүйлгээний ангилал засах, Гүйлгээг шүүх болон салгах, Гүйлгээний дүрэм үүсгэх
- Онлайн тодорхойлолт авах

Давуу талууд:

- Илүү олон нэмэлт үйлчилгээнүүдийг агуулсан **Хадгаламж, Зээл, Карт** цэс
- Хиймэл оюун ухаанд суурилсан Гүйлгээний болон Төлбөрийн **Товч холбоос**
- Таны санхүүг таны өмнөөс хөтлөх автомат хөтөч **Миний Санхүү** цэс
- Хэрэглээний төлбөр төлөлтийг хялбаршуулсан **Календарь**
- Дансны мэдээллийг авах, баталгаажуулах **Онлайн тодорхойлолт** үйлчилгээ
- Харилцагчдад хэрэгцээт мэдээллүүдийг хүргэх **Сонордуулга** үйлчилгээ
- Интернэт банкыг ашиглахад туслах **Тусламж** цэс
- Салбарын ачааллыг харуулах шинэчлэгдсэн **Байршил** цэс

1.1.5 Гарын авлага, заавар зөвлөмжийг хаанаас авах вэ?

Харилцагчдад зориулсан Интернэт банкны Гарын авлага болон Түгээмэл Асуулт Хариулт нь www.golomtbank.com болон e.golomtbank.com (?) Тусламж цэс дотор байршина. Мөн Интернэт банкыг ашиглахтай холбоотой демо зааварчилгаа нь e.golomtbank.com дээр байршина.

1.1.6 Хэрхэн Интернэт банкны холболтоос гарах вэ?

Та Интернэт банк үйлчилгээнээс гарахын тулд дэлгэцийн баруун дээд буланд байрлах “Хувийн тохиргоо” цэсвний хамгийн доор “Гарах” товч дээр дарснаар интернэт банкны холболтоос гарна.

1.1.7 Гүйлгээ хийх эрхтэй байгууллагын хувьд Байгууллага зөвхөн интернэт банкаар гүйлгээ хийх эрхтэй, бусад нэмэлт үйлчилгээ байхгүй юу?

Доор бичигдээгүй эсвэл тусгайлан дурдаагүй үйлдэл, feature нь хуучин хувилбартай адилхан байна.

- Гүйлгээ (Өөрийн данс хооронд, Голомт данс хооронд, Банк хооронд, Гадаад шилжүүлэг, Зээлийн төлбөр төлөх, Кредит картын төлбөр, Гүйлгээний лавлагаа, Дансны дэвтэр, Загвар гүйлгээ)
- Цалингийн гүйлгээ хийх (Цалингийн гүйлгээ хийх, Гүйлгээ хянах, Цалингийн гүйлгээний түүх)

- Харилцах (Харилцах дансны жагсаалт/Дэлгэрэнгүй)
- Хадгаламж (Хадгаламжийн дансны жагсаалт/Дэлгэрэнгүй)
- Төлбөр төлөх (Төлбөрийн жагсаалт, Төлбөрийн календарь, Хэрэглээний төлбөр, Нэгж, карт сунгах, Торгууль төлөх, Гаалийн төлбөр төлөх, Татвар төлөх, Нийгмийн даатгал төлөх)
- Карт (Кредит карт: Картын жагсаалт/дэлгэрэнгүй, Кредит картын төлбөр төлөх; Дебит карт: Картын жагсаалт/дэлгэрэнгүй)
- Зээл (Зээлийн дансны жагсаалт, Зээлийн хуулга, Зээлийн эргэн төлөх хуваарь, Зээлийн төлбөр төлөх, Зээл хаах тооцоолуур)
- Хүсэлт илгээх (Тодорхойлолтын хүсэлт, Тендерийн баталгааны хүсэлт, Хүсэлтийн лавлагаа)
- Хувийн мэдээлэл (Нэвтрэх нэр солих, Нууц үг солих, Гүйлгээний эрхийн лавлагаа)
- Тусламж цэс (Салбар, АТМ, Ханшийн самбар, Онлайн зөвлөх, Байгууллагын интернэт банкны заавар, Чат бот)
- Худалдааны санхүүжилт (Аккредитивын жагсаалт, Баталгааны жагсаалт)

1.2 Бүртгэл

1.2.1 16 настай Интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлж болох уу?

Харилцагч нь интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлэхийн тулд 18 болон түүнээс дээш настай байх шаардлагатай тул насанд хүрээгүй харилцагчид бүртгүүлэх боломжгүй.

1.2.2 Хэрхэн Интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлэх вэ?

Та интернэт банкны үйлчилгээнд дараах 2 сувгийн аль нэгээр нь дамжуулан бүртгүүлэх боломжтой:

- Интернэт банкны Нэвтрэх нүүрэн дэх “Онлайн бүртгэл” цэсийг ашиглах
- Өөрт ойр байрлах дурын салбар, тооцооны төвд Цахим үнэмлэхээ авч очин бүртгүүлэх

1.2.3 Онлайн бүртгэл гэж юу вэ?

“Онлайн бүртгэл” гэдэг нь харилцагч банкны салбарт ирэлгүйгээр Интернет банкны вэб хаягаар дамжуулан интернет банкны үйлчилгээнд шинээр бүртгүүлэх үйлчилгээ юм. Онлайнар интернет банкны үйлчилгээнд бүртгүүлснээр танд өдрийн гүйлгээний дүн хязгаарлалттай буюу “Хязгаарлагдмал эрх” нээгдэх бөгөөд та салбарт хандан өдрийн гүйлгээний дүнгээ нэмэгдүүлэх боломжтой.

1.2.4 Гадаад улсын иргэн онлайнар Интернет банкны үйлчилгээнд бүртгүүлж болох уу? / Гадаадад байгаа хүн дансан дээрээ интернет банкны эрх яаж нээлгэх вэ?

Гадаад улсын иргэн онлайнар бүртгүүлж болохгүй. Харин Гадаадад байгаа Голомт банкны харилцагч интернет банкны /энгийн мэдээлэл харах/ үйлчилгээ авах хүсэлтийг Салбар, Тооцооны Төв болон Лавлах төвийн /1800-1646/ ажилтан тус тус хүлээн авна. Харилцагч дараах мэдээллийг internetbank@golomtbank.com хаяг руу өөрийн бүртгэлтэй и-мэйл хаягнаас явуулна.

1. Гадаад паспортын зурагтай болон хүчинтэй хугацаа бүхий хуудсууд
2. Картын дугаар (эхний 4 болон сүүлийн 4 орон)
3. Тухайн картаар хамгийн сүүлд хийгдсэн 3 гүйлгээний товч мэдээлэл
4. Гараар бичсэн хүсэлт – “ИНТЕРНЭТ БАНКНЫ ЭНГИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРАХ ЭРХ” нээж өгнө үү гэсэн утгатай баталгаат гарын үсэгтэй хүсэлт байх /скайнер, фото зургаар хүлээн авах/

1.2.5 Гадаадад байгаа харилцагч яагаад интернет банкинд онлайнар бүртгүүлж болохгүй вэ?

Интернет банкны үйлчилгээнд онлайнар бүртгүүлэхийн тулд тухайн харилцагчийн мэдээлэл нь (харилцагчийн дугаар, баталгаат гарын үсэг зураг, бүртгэлтэй утас, и-мэйл хаяг гэх мэт) банкинд бүртгэлтэй байх шаардлагатай.

1.3 Нөхцөл

1.3.1 Интернет банк үйлчилгээ нь хураамжтай юу?

Интернет банкны үйлчилгээ нь хураамжгүй.

1.3.2 Интернет банкны хугацааг хэрхэн сунгуулах вэ?

Интернет банкаараа нэвтэрч ороогүй 6 сар болсон тохиолдолд эрх идэвхгүй болно. Интернет банкны эрхийг сэргээхийн тулд:

- Иргэн бол Бүртгэлтэй утасны дугаараас 1800-1646 лавлах утсанд залгаж сэргээх
- Байгууллага бол Өөрийн үндсэн салбарт хандан гэрээг сунгах боломжтой.

1.4 Нэвтрэх хуудас

1.4.1 Интернет банкны хэлийг яаж солих вэ?

Интернет банкны Нэвтрэх хэсгийн зүүн дээр байрлах "MON", "ENG" эсвэл "汉语" товч дээр дарж Монгол, Англи эсвэл Хятад хэлийг сонгох боломжтой.

1.4.2 Хэрхэн Интернет банкинд нэвтрэх вэ?

Та интернет банкуу нэвтрэхийн тулд Нэвтрэх хэсэгт интернет банкны Нэвтрэх нэр болон Нэвтрэх нууц үгээ оруулан "Нэвтрэх" товч дээр дарна.

2. ИНТЕРНЭТ БАНКНЫ ЛИМИТ, ЭРХ НЭМЭГДҮҮЛЭХ

2.1 Лимит

2.1.1 Интернет банкны өдрийн гүйлгээний лимит хэд байдаг вэ? Лимитээ шууд нэмэх боломжтой юу?

Энгийн эрх бол өдөрт дээд тал нь 20 сая төгрөг шилжүүлэх боломжтой. Хэрэв гүйлгээний лимитээ нэмэгдүүлэх бол салбарт хүсэлт гаргах бөгөөд

- Иргэн бол салбар харгалзахгүй
- Байгууллагын банкны газрын харилцагч байгууллага бол 100 сая төгрөг хүртэл салбар харгалзахгүй
- Салбар, Тооцооны Төвийн харилцагч байгууллага бол үндсэн салбартаа албан хүсэлт гаргана.

2.1.2 Интернет банкаар өөрийн данс хооронд хийсэн гүйлгээг өдрийн гүйлгээний лимитэд тооцдоггүй байх боломж бий юу?

Өөрийн данс хооронд гүйлгээ хийхэд өдрийн гүйлгээний лимитэд тооцогдохгүй.

2.2 Эрх

2.2.1 Интернет банкны эрх хэдэн жил байдаг вэ?

Интернет банкны үйлчилгээний Энгийн эрх, Хязгаарлагдмал эрх, Онлайн хадгаламжийн эрх нь хугацаагүй байдаг бол Тусгай эрхийн гэрээ нь 1 жилийн хугацаатай байна.

2.2.2 Хязгаарлагдмал эрхээ яаж нэмэгдүүлэх вэ?

Харилцагч нь хязгаарлагдмал эрхээ нэмэгдүүлэхийн тулд дурын салбарт очин шинээр гэрээ байгуулна.

2.2.3 Байгууллага Интернет банкны эрх авахад ямар бичиг баримт шаардлагатай байдаг вэ?

Байгууллага нь өөрийн үндсэн салбартаа хандан, дараах материалуудыг бүрдүүлэх шаардлагатай.

- Интернет банкны үйлчилгээ авах хүсэлтийг бөглөж байгууллагын данснаас зарлагын гүйлгээ хийх эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, байгууллагын тамга дарж баталгаажуулсан байх;
- Байгууллагын эрх бүхий ажилтны гарын үсэг, тамга бүхий Интернет банкны үйлчилгээ хүсэх тухай албан бичиг;
- Байгууллагын Интернет банкны гүйлгээ хийх эрх бүхий албан тушаалтны бичиг баримтууд;
- Гүйлгээ хийх эрх бүхий харилцагч өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд нотариатаар баталгаажуулсан итгэмжлэл, цахим үнэмлэхний хуулбарын хамт

2.2.4 Байгууллагын Интернэт банкны эрх дээд тал нь хэдэн хэрэглэгч бүртгэж болох вэ?

Тухайн байгууллагын хүсэлтийн дагуу олон хэрэглэгчийг бүртгэх боломжтой.

3. ГҮЙЛГЭЭ

3.1 Өөрийн данс хооронд

3.1.1 Онлайнаар данс нээлгэсэн харилцагч тухайн данснаасаа гүйлгээ хийж болох уу? Интернэт банкны эрх дагалдах уу?

Тийм, интернэт банкны эрх дагалддаг. Гэхдээ онлайн дансны эрх нь зөвхөн өөрийн данс хооронд гүйлгээ хийх эрхтэй байдаг.

3.2 Банк хооронд

3.2.1 Интернэт банкаар банк хооронд гүйлгээ хийхэд шимтгэл нь хэд байдаг вэ?

Интернэт банк ашиглан банк хооронд гүйлгээ хийхэд шимтгэл нь:

- 3,000,000₮ хүртэл бол 300₮
- 3,000,001₮-с дээш бол 400₮ байна.

3.2.2 Интернэт банкаар банк хоорондын гүйлгээ хийвэл хэзээ орох вэ?

Банк хоорондын 3 сая төгрөгөөс дээш гүйлгээ нь Монгол банкаар дамжин хийгддэг. Монгол банкны гүйлгээний цагийн хуваарийн дагуу ажлын өдрүүдийн 09:00-16:00 цагийн хооронд энэхүү гүйлгээ нь хийгддэг. Энэ цагаас бусад цагаар хийгдсэн гүйлгээ нь дараагийн ажлын өдөр Монгол банк руу илгээгдэн тухайн хүлээн авагч банк руу гүйлгээ нь хийгддэг.

3.2.3 Интернет банкаар байгууллагынхаа данс хооронд их дүнтэй гүйлгээ ажлын цагийн дараа хийвэл шууд орох уу?

Голомт хооронд:

- 99,999,999₮ буюу түүнтэй тэнцэх валют хүртэлх дүнтэй гүйлгээ 24x7 горимоор;
- 100 сая төгрөг түүнтэй тэнцэх валютаас дээш дүнтэй гүйлгээ нь ажлын өдрийн 09:00-18:00 цагийн хооронд хийгдэх ба үүнээс хойш хийгдсэн гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэнэ;

Цалингийн багц гүйлгээ:

- Ажлын өдрийн 09:00-17:00 цагийн хооронд 2 цаг тутам оруулсан файлыг шалган гүйлгээг хийнэ.

3.3 Гадаад шилжүүлэг

3.3.1 Интернет банкаар гадаад гуйвуулгын гүйлгээ хийж болох уу?

Боломжтой. Та Интернет банкны “Гүйлгээ” үндсэн цэсний “Гадаад гүйлгээ” дэд цэсийг ашиглан гадаадын банкны данс руу шилжүүлэг хийх боломжтой.

3.4 Гүйлгээний лавлагаа

3.4.1 Интернет банкаар гүйлгээ хийсэн баримтаа хэрхэн авах вэ? Тамгатай баримт гарах уу?

Та Интернет банкны “Гүйлгээ” үндсэн цэсний “Гүйлгээний лавлагаа” дэд цэсээр дамжуулан өөрийн данснаас хийгдсэн гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг шүүн харах болон Голомт банкны тамгатай гүйлгээний баримтыг татах боломжтой.

3.5 Захиалгат шилжүүлэг

3.5.1 Зээлийн данстай захиалгат шилжүүлгийг холбож болох уу?

Болно. Зээлийн эргэн төлөлтөө харилцах дансандаа байршуулснаар Захиалгат шилжүүлэг үйлчилгээгээр дамжуулан зээлийн данс руу эргэн төлөлт хийгдэнэ.

3.6 Э-токен

3.6.1 Э-токен гэж юу вэ?

Э-токен нь нэг удаагийн нууц үг (40 секунд тутамд өөрчлөгддөг) үүсгэгч төхөөрөмж юм. Уг төхөөрөмжийг ашигласнаар харилцагчийн дансны мэдээлэл, гүйлгээний нууцлал, аюулгүй байдал нь илүү өндөр байх болно.

3.6.2 Э-токен төхөөрөмжийн үнэ хэд вэ? Хувь хүн авах боломжтой юу?

Э-токен төхөөрөмжийн үнэ нь 40000₮. Харилцагчид энэхүү төхөөрөмжийг цоо шинээр олгон зардаг ба хуучин төхөөрөмжийг өөр харилцагч дээр ашигладаггүй юм. Иймд энэхүү төлбөр нь барьцаа хураамж биш юм. Хувь хүн э-токен төхөөрөмж авч болно.

3.6.3 Байгууллага э-токен төхөөрөмжийг 50 сая төгрөгний гүйлгээ хийх үед ашиглах уу?

Байгууллага нь э-токен төхөөрөмжийг 50 сая төгрөгөөс дээш гүйлгээ хийх эрх дээр ашиглана.

3.7 Бусад

3.7.1 Түргэн холбоос цэсэнд хадгалсан гүйлгээний загвар хадгалагдах уу?

"Түргэн холбоос" цэс нь гүйлгээний загвар хадгалдаггүй, харин харилцагч таны тухайн өдөр хамгийн өндөр хийх магадлалтай гүйлгээг харуулах үйлчилгээ юм.

3.7.2 Интернетгүй тохиолдолд гүйлгээ хийх ямар боломж байгаа вэ?

Харилцагч Интернет болон Смарт банк ашиглах боломжгүй тохиолдолд Мобайл банк үйлчилгээг ашиглан Голомт банкны дансруу эсвэл банк хооронд гүйлгээ хийх боломжтой. Мобайл банкны үйлчилгээнд www.egolomt.mn веб хаяг руу хандана “Үйлчилгээ” цэсний “Мобайл банк 2.0” хэсгээр орон бүртгүүлэх боломжтой.

4. ХАРИЛЦАХ

4.1 Интернет банк дээр хамтран эзэмшдэг дансаа хэрхэн нэмэх вэ?

- Иргэн бол дурын Салбар, Тооцооны Төвд хандан дансны үндсэн эзэмшигч нь хүсэлт өгснөөр дансыг нэмж болно.
- Байгууллага бол анх интернет банкны эрх авсан үндсэн салбартаа хандан хүсэлт бөглөж, байгууллагын данснаас зарлага гаргах эрх бүхий ажилтнуудын гарын үсэг, байгууллагын тамга бүхий албан бичгийн хамт өгнө.

4.2 Интернет банкаар хуулгаа хэрхэн шалгах вэ? Хэдий хугацааны хуулга шалгах боломжтой вэ?

Дансны хуулгыг Интернет банкны “Харилцах” цэсэнд байрлах өөрийн аль нэг данс дээр дарж “Дансны хуулга” сонголтыг сонгон харах боломжтой. Та Дансны хуулгыг 7 хоног, Сар, Улирал гэсэн сонголттойгоор харж болох бөгөөд хамгийн уртдаа 93 хоногийн хугацааны хуулгыг дэлгэцээр харах эсвэл 365 хоногийн хуулгыг файлаар татах боломжтой.

4.3 Гүйлгээний хуулга татахад ямар форматаар татагдах вэ?

Гүйлгээний хуулга нь pdf форматаар татагдана.

4.4 Файлаар татагдсан дансны хуулга нь тамгагүй тул хүчин төгөлдөр бичиг баримтанд тооцогдох уу?

Тухайн хүлээн авагч байгууллагын шаардлагаас хамааран хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр бус байж болно.

5. ХАДГАЛАМЖ

5.1 Хадгаламж хаах

5.1.1 Интернет банкаар хадгаламжийнхаа хугацааг цуцалж болох уу?

Боломжтой. Та Интернет банкны "Хадгаламж" үндсэн цэсний "Хадгаламж хаах" дэд цэсийг ашиглан зааврын дагуу хадгаламжийн данснаа хаах боломжтой.

5.2 Хадгаламж сунгах

5.2.1 Интернет банкаар бүх төрлийн хадгаламжийн хугацааг сунгаж болох уу?

Интернет банкаар зөвхөн Энгийн хугацаатай хадгаламж болон Хуримтлалын хадгаламжийг сунгах боломжтой. Хэрэв бусад хугацаатай хадгаламж сунгах бол тухайн хадгаламж нь энгийн хугацаатай хадгаламж болж сунгагдана.

6. ЗЭЭЛ

6.1 Зээлийн төлбөр

6.1.1 Интернэт банкаараа зээлээ төлж болох уу? Урьдчилж зээлээ хааж болох уу?

Боломжтой. Та Интернэт банкны “Зээл” үндсэн цэсний “Зээлийн төлбөр төлөх” хэсгээр дамжуулан зээлийн төлбөрөө төлөх эсвэл “Зээл хаах” хэсгээр дамжуулан зээлээ урьдчилж хаах боломжтой.

6.1.2 Зээлийн төлбөр төлөх цэсээр ямар, ямар зээл төлж болох вэ?

Одоогоор зөвхөн төгрөгийн зээлийн төлбөрийг төлөх боломжтой.

6.2 Зээлийн график

6.2.1 Интернэт банкаар зээлийн мэдээллийг харж болох уу? Хугацаа, зээлийн төлөлт, хүү, нийт зээлийн хэмжээ гэх мэт.

Боломжтой. Та Интернэт банкаар орон “Зээл” үндсэн цэсний “Зээлийн график” дэд цэсээр дамжуулан зээлийн үлдэгдэл, хүүгийн төлбөр, үндсэн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн хуваарь зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

7. КАРТ

7.1 Карт захиалга

7.1.1 Интернэт банкаар кредит карт захиалах боломжтой юу?

Интернэт банкаар кредит карт захиалах боломжгүй зөвхөн дебит карт захиалах боломжтой.

7.2 Пин код

7.2.1 Картын пин кодыг интернэт банкаар захиалж авах үйлчилгээ байгаа юу?

Байгаа. Та Интернэт банкны “Карт” үндсэн цэснээс пин код авах картаа сонгон “Пин-код авах” хэсгээр дамжуулан авах боломжтой.

7.3 И-код

7.3.1 И-код гэж юу вэ? Пин кодоос юугаараа ялгаатай вэ? Картын И-код хэрхэн авах вэ?

И-код нь Картын пин кодоос ялгаатай бөгөөд харилцагч төлбөрийн картаа ашиглан худалдаа үйлчилгээ эрхлэгч байгууллагын вэб сайтаас онлайннаар худалдан авалт хийх үед уг гүйлгээг И-кодоор баталгаажуулдаг юм.

/Жич: хэрэв та э-токен төхөөрөмжтэй бол И-код авах шаардлагагүй./ И-код авахын тулд Интернэт банкны “Карт” үндсэн цэснээс и-код авах картаа сонгон “И-код авах” товч дээр дарж дурын 4 оронтой тоог оруулан авах боломжтой.

7.3.2 И-кодоо мартсан тохиолдолд Интернэт банкаар авах боломжтой юу?

Та Интернэт банкны “Карт” үндсэн цэснээс и-код авах картаа сонгон “И-код авах” хэсгээр дамжуулан өөрийн дурын 4 оронтой тоог оруулан шинээр авах эсвэл солих боломжтой.

7.3.3 Гадаадад байгаа тохиолдолд И-код хэрхэн авах вэ? /и-банктай, и-банкгүй харилцагчийн хувьд/

- Хэрэв харилцагч нь и-банктай бол Интернэт банкны “Карт” үндсэн цэсний “И-код авах” дэд цэсээр дамжуулан дурын 4 оронтой тоог оруулан авах боломжтой.
- Хэрэв харилцагч нь и-банкны эрхгүй, гадаадад байгаа тохиолдолд гараар бичсэн хүсэлт, гадаад паспортын хуулбар, картын дугаарын эхний болон сүүлийн 4 орон, сүүлийн гурван гүйлгээний мэдээллийг хавсарган өөрийн бүртгэлтэй и-мэйл хаягнаас internetbank@golomtbank.com хаягруу илгээн И-код авах боломжтой.

7.3.4 Э-токентой бол интернэт худалдан авалт хийхэд И-код авах шаардлагатай юу?

Хэрэв харилцагч э-токен төхөөрөмжтэй бол и-код авах шаардлагагүй. Худалдан авалт хийхдээ э-токеноо ашиглана. Ингэхийн өмнө харилцагчийн картыг Э-токентэй холбон бүртгэх шаардлагатай ба үүнийг салбар дээр очин бүртгүүлэх боломжтой.

8. ТӨЛБӨР

8.1 Байрны төлбөрийг Интернэт банкнаас төлж болох уу?

Боломжтой. Та Интернэт банкны “Төлбөр” үндсэн цэсний “Хэрэглээний төлбөр” дэд цэсээр хандан таны СӨХ/Контор бүртгэлтэй байгаа эсэхийг шалгаснаар төлөлт хийх боломжтой.

9. МИНИЙ САНХҮҮ

9.1 Ерөнхий

9.1.1 “Миний санхүү” гэж юу вэ?

“Миний санхүү” үйлчилгээ нь харилцагч нарт санхүүгийн гүйлгээ, мэдээллээ хялбараар удирдах, өөрийн орлого зарлагаа хялбараар ангилах, хэрэглээгээ төсөвлөх болон зарцуулалтаа ухаалгаар хянах боломжийг олгох үйлчилгээ юм.

9.2 Төсөв

9.2.1 Төсөв үүсгэх ямар давуу талууд байгаа вэ?

Та хэрэглээндээ хэр их мөнгө зарцуулж байгаагаа нарийн мэддэг үү? Өнгөрсөн сар та ХҮНС-дээ хэр их мөнгө зарцуулж, ГАДУУР ХООЛЛОЛТ-нд хэр их зардал гаргасан бол? Хэрэв та сайн хэлж мэдэхгүй байгаа бол танд Төсөв үүсгэх боломж нэн шаардлагатай байна. Хязгаартай хэмжээнд байлгахыг, хүссэн зардлаа төсөвлөж түүнийг автоматаар хянах боломж нь танд маш их таалагдах болно. Хувийн болон өрхийн төсөв үүсгэж түүнийг тогтмол хянаж байх нь дараах олон давуу талуудтай:


- Өөрийн сар бүрийн зарцуулалтын хэмжээг байнга мэдэх
- Төсвөөс хэтрэхгүйгээр ЧӨЛӨӨТ ЦАГ, ГАДУУР ХООЛЛОЛТ-нд мөнгөө зарцуулах
- Ирээдүйд зориулж хуримтлал үүсгэх
- Мөнгөнд бага бухимдах

9.2.2 Миний санхүү – Төсвийн жагсаалт - “Хамтарсан” гэсэн төсөв нь ямар учиртай вэ?

“Миний санхүү – Төсвийн жагсаалт – Хамтарсан төсөв” нь харилцагчдад гэр бүлийн гишүүн, дотны найзуудтайгаа хамтран “Хамтарсан төсөв” үүсгэж зарцуулалтаа хамт хянах боломжийг олгоно. Бусад гишүүдийн зарцуулалтын зөвхөн нийт дүн харагдах бөгөөд гүйлгээний задаргаа харагдахгүй.

9.3 Гүйлгээ

9.3.1 Миний гүйлгээ яагаад буруу ангилагдсан бэ? Ийм тохиолдолд яах вэ?

Таны картаар хийсэн гүйлгээ нь буруу төрөлд ангилагдсан бол энэ нь тухайн Картаар үйлчлүүлэгч байгууллага (КҮБ) нь анхлан бүртгүүлсэн зориулалтаасаа өөр үйлчилгээг хүргэж байж болно. Хэрэв таны гүйлгээ буруу ангилагдсан бол та “Миний Санхүү” үндсэн цэсний “Гүйлгээний жагсаалт” дэд цэс рүү орон тухайн гүйлгээг засах буюу -ны icon дээр дарж гүйлгээний ангиллыг солих боломжтой.

9.3.2 Бусад банкны карт, дансаар хийсэн гүйлгээгээ авто холбуулах боломжтой юу?

Авто холбох боломж байхгүй. Бэлнээр эсвэл бусад банкны данс, картаар хийсэн гүйлгээгээ өөрөө Гүйлгээ нэмэх цэсээр оруулах боломжтой.

9.3.3 Миний санхүү – “Гүйлгээний дүрэм” цэс нь ямар учиртай вэ?

“Миний санхүү – Гүйлгээний дүрэм” цэс нь Гүйлгээний дүрмийг хүссэнээрээ зохиох боломжийг олгох бөгөөд таны үүсгэсэн дүрмийн дагуу гүйлгээнүүд автоматаар ангилагдана.

9.3.4 Миний санхүү – Төсвийн жагсаалт – “Онцгой” дотор хамрагч нэмснээр цаад хүндээ ямар мэдээлэл очих вэ? Интернэт банкгүй харилцагчийг хамтрагчаар нэмж болох уу? Хамтрагч нь тухайн төсөвт хэрхэн мөнгө хийх, худалдан авалт хийх вэ?

“Миний санхүү – Төсвийн жагсаалт – Онцгой төсөв” дотор хамтрагч нэмснээр цаад хүнд нь Хамтарсан төсвийн хүсэлт очно. Хүсэлтийг зөвшөөрснөөр дундын Хамтарсан төсөв амжилттай үүснэ.

Интернэт банкгүй харилцагчийг хамтрагчаар нэмж болох ч цаад хүнд нь Хамтарсан төсвийн хүсэлт очихгүй учир Хамтарсан төсөв нээх боломжгүй.

Хамтарсан төсөвт мөнгө хийх үйлдэл гэж байхгүй, харин худалдан авалтын хувьд гүйлгээ нь “Миний санхүү – Төсвийн жагсаалт” дотор автоматаар бүртгэгдэнэ.

9.4 Ангилал

9.4.1 Миний гүйлгээг хэрхэн ангилж байгаа вэ?

Таны карт болон дансаар хийгдсэн гүйлгээнүүдийг 22 зарлагын болон 5 орлогын ангилал руу автоматаар хуваарилж байгаа.

Жишээ нь:

- Хүнсний дэлгүүрээс худалдан авалт хийхэд ХҮНС ангилал руу орно.
- Онлайннар Кино театрын билет худалдан авахад ЧӨЛӨӨТ ЦАГ ангилал руу орно.
- Смарт банкаар утасны төлбөр төлөхөд УТАСНЫ ТӨЛБӨР ангилал руу орно.
- Таксины жолооч руу мөнгө шилжүүлэх үед гүйлгээний утганд "taxi" эсвэл "такси" бичсэн тохиолдолд ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ангилал руу орно.

9.4.2 Миний санхүү – Ангиллын жагсаалт дотор хугацаа нь зөвхөн энэ сарын мэдээлэл харагдах уу? Жишээ нь: Цалин гэсэн ангилалд сүүлийн удаагийн цалингийн мэдээлэл харагдаж байна.

Ангиллын жагсаалт дотор хугацаа хамаагүй, зөвхөн бүх ангиллуудын жагсаалт л хугацаанаас үл хамааран харагдана.

9.4.3 Шилжүүлэг гэж ямар гүйлгээний төрөл вэ?

Таны өөрийн данс хооронд хийсэн гүйлгээ таны хувийн санхүүгийн нийт дүнд нөлөө үзүүлэхгүй учраас таны Зарлага эсвэл Орлого болж бүртгэгдэхгүй харин тусдаа Шилжүүлэг гэсэн гүйлгээний төрөл рүү хуваарилагдах юм. Үүнд дараах гүйлгээнүүд орж байгаа:

- Өөрийн харилцах данс хооронд хийгдсэн гүйлгээ
- Өөрийн хадгаламж руу орлого хийсэн гүйлгээ
- Өөрийн кредит картын төлбөр

10. ОНЛАЙН ТОДОРХОЙЛОЛТ

10.1 Интернет банкаараа дансны онлайн тодорхойлолтыг хэрхэн авах вэ? Тодорхойлолтын кодыг хаанаас авах вэ?

Та Интернет банкны “Онлайн тодорхойлолт” үндсэн цэснээс тодорхойлолтын төрлийг сонгон банкны албан ёсны тодорхойлолтыг авах боломжтой. Тухайн тодорхойлолт дээр QR код гарах бөгөөд та Смарт банкны нэвтрэх хэсгээс “Тодорхойлолтын QR код уншигч” дээр даран тухайн тодорхойлолтыг баталгаажуулах боломжтой.

11. ХУВИЙН ТОХИРГОО

11.1 Хувийн мэдээлэл

11.1.1 Утасны дугаар болон и-мэйл хаяг зэрэг мэдээллээ яаж өөрчлөх вэ?

Та утасны дугаар болон и-мэйл хаяг зэрэг мэдээллээ Интернет банкны баруун дээд буланд байрлах “Хувийн тохиргоо” цэсний “Хувийн мэдээлэл” хэсэг рүү орон солих боломжтой.

11.1.2 Онлайн бүртгэлээр банкинд бүртгэлтэй имэйл хаяг, утасны дугаараа өөрчилж болох уу?

Онлайнаар бүртгүүлсэн харилцагч банкинд бүртгэлтэй имэйл хаяг, утасны дугаар болон бусад холбогдох хувийн мэдээллээ Интернет банкны “Хувийн тохиргоо” цэсний “Хувийн мэдээлэл” хэсгээр дамжуулан солих боломжтой.

11.1.3 Интернет банкны нууцлалаа алдсан бол яах вэ?

Харилцагч нь нэн даруй интернет банкаараа нэвтрэн “Хувийн тохиргоо” цэсээр Нэвтрэх нэр болон Нууц үгээ солихыг зөвлөнө. Мөн интернет банк үйлчилгээнд бүртгэлтэй и-мэйл хаягны нууц үгээ солихыг зөвлөнө. Учир нь гүйлгээний мэдээлэл, Нэвтрэх нэр болон нууц үгээ шинэчлэн авах тохиолдолд мэдээлэл нь уг и-мэйл хаяг дээр ирэх тул мэдээллээ дахин алдах магадлалтай. Шаардлагатай тохиолдолд бүртгэлтэй и-мэйл хаягаа солих хэрэгтэй. Хэрэв интернет банкны Нэвтрэх нэр болон нууц үгээ алдсаны дараа интернет банкиндаа нэвтэрч чадахгүй байгаа тохиолдолд банкны салбарт хандан эрхийг хаах, бүртгэлтэй и-мэйл хаягийг солих нууц үгийг шинэ и-мэйл хаягаар илгээх шаардлагатай. Хэрэв харилцагч интернетгүй орчинд байгаа тохиолдолд Лавлах төвийн 1800-1646 дугаарт холбогдон интернет банкны эрхээ блоклоулах боломжтой.

11.2 Нэвтрэх нэр

11.2.1 Интернет банкны үйлчилгээнд бүртгүүлэхэд банкнаас өгсөн нэвтрэх нэр болон нэвтрэх нууц үгийг сольж болох уу?

Та шинээр интернет банкны үйлчилгээнд бүртгүүлэхэд банкнаас нэг удаагийн нэвтрэх нэр болон нэвтрэх нууц үг өгөх бөгөөд та интернет банкинд нэвтрэн орохдоо үүнийг ашиглах ба нэвтэрч орсны дараагаар тус нэвтрэх нэр болон нууц үгээ заавал солих шаардлагатай.

11.2.2 Интернет банкаар хэрэглэгчийн нэвтрэх нэрийг сольж болох уу?

Банкнаас олгосон хэрэглэгчийн нэвтрэх нэрийг интернет банкаар солих боломжтой. Та Интернет банкаар орон дэлгэцийн баруун дээд буланд байрлах “Хувийн тохиргоо” цэсний “Нэвтрэх нэр солих” хэсгээр орон Интернет болон Смарт банкны нэвтрэх нэрийг солих боломжтой.

11.2.3 Харилцагчийн дугаар гэж юу вэ? Ямар тохиолдолд хэрэглэх вэ?

Харилцагчийн дугаар нь банкны систем дээр харагдах харилцагчийн банкны бүртгэлийн дугаар юм. Банкны дотоод хэрэгцээнд болон байгууллагын интернет банкны хэрэглэгчид ашиглагдана.

11.2.4 Интернэт банкинд нэвтрэх банкнаас олгосон хэрэглэгчийн дугаараа мартсан тохиолдолд хэрхэн сэргээх вэ?

Үндсэн салбарт цахим үнэмлэхтэй хандаж хэрэглэгчийн дугаарыг авах боломжтой. Хэрэглэгчийн дугаар нь таны дансны мэдээллийг авах, таны данснаас гүйлгээ хийх чухал ач холбогдолтой мэдээлэл юм.

- Байгууллага бол албан бичиг
- Иргэн бол цахим үнэмлэхтэйгээ дурын салбарт хандан авах боломжтой.

11.3 Нууц үг

11.3.1 Онлайнээр бүртгүүлсэн харилцагчийн хувьд, банкнаас ирүүлсэн хоёр янзын нууц үгний алинаар нь нэвтрэх вэ?

Танд интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлэх үед Нэвтрэх нууц үг болон Батлах нууц үг гэсэн 2 төрлийн нууц үг олгох бөгөөд та Интернэт банкаараа нэвтрэхдээ Нэвтрэх нууц үгийг ашиглан нэвтэрч харин Батлах нууц үгийг гүйлгээ хийхдээ ашиглана.

11.3.2 Нууц үгээ хэрхэн солих вэ?

Та Нэвтрэх болон Батлах нууц үгээ Интернэт банк руу нэвтрэн орж дэлгэцийн баруун дээд буланд байрлах “Хувийн тохиргоо” цэсний “Нууц үг солих” хэсгээр дамжуулан солих боломжтой.

11.3.3 Интернэт банкинд нэвтрэх нууц үгээ мартсан бол яаж дахиж авах вэ?

Харилцагч нь Нэвтрэх эсвэл Батлах нууц үгээ мартсан бол Интернэт банк руу нэвтрэн орохын өмнө Нэвтрэх хэсгийн “Мартсан?” дээр дарж зааварчилгааны дагуу сольж авах боломжтой.

11.3.4 Батлах нууц үг ашиглахгүйгээр гүйлгээ хийх боломжтой юу?

Батлах нууц үг ашиглахгүйгээр гүйлгээ хийх боломжгүй. Хэрэв та Батлах нууц үгээ мартсан бол Интернет банкнд нэвтэрч орохын өмнө Нэвтрэх хэсэгт “Мартсан?” товч дээр даран зааврын дагуу шинээр үүсгэх боломжтой.

11.3.5 Интернет банкнд нэвтрэх нууц үгээ блокчлох, блокоо яаж гаргах вэ?

- Иргэн бол өөрийн бүртгэлтэй утасны дугаараас 1800-1646 лавлах дугаарт залгах эсвэл дурын Салбар, Тооцооны Төвд хандан хүсэлт бөглөх;
- Байгууллага бол нууц үгийн блок гаргах хүсэлтийг дурын Салбар, Тооцооны Төвд албан бичгээр гаргана.

11.3.6 Байгууллагын Интернет банкны нууц үгээ блоколсон ба э-токен төхөөрөмж ажиллахгүй байна?

Байгууллагын харилцагч блок гаргах хүсэлтийг дурын Салбар, Тооцооны Төвд албан бичгээр гаргана.

Э-токен төхөөрөмж ажиллахгүй буюу товчлуур дээр дарахад дэлгэцэн дээр тоо гарахгүй тохиолдолд Салбар, Тооцооны Төвд хандан Э-токеныг солих арга хэмжээ авна. Хэрэв харилцагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалаагүй /ахуйн бус гэмтэл/ тохиолдолд харилцагчийн интернет банкны эрх анх нээлгэсэн Салбар, Тооцооны Төв нь харилцагчид үнэ, төлбөргүй дахин олгоно.

12. ТУСЛАМЖ

12.1 Интернет банкны ханшийн самбар тогтмол ямар хугацаанд хэдэн цагт шинэчлэгдэх вэ?

Интернет банкны Ханшийн самбар нь банкны зарласан ханшийг шууд дамжуулдаг болно.

12.2 Салбар, АТМ –ийн байршлыг жагсаалтаар харах боломжтой юу?

Салбар, АТМ-ийн байршлыг жагсаалтаар харах боломжтой.